



A Study of the Defense Establishment and Its Current Challenges

Battogtokh Baljinnyam¹, Shijee Palamdorj²

¹Colonel, Senior researcher, Defense studies center, Defense Research Institute of Mongolia
E-mail address: b.baljinnyam24@gmail.com, ORCID: 0009-0004-4243-7064

²Sc.D, Professor, Leading researcher, Center for military art, Defense Research Institute of Mongolia
E-mail address: Palamdorjsh1948@gmail.com, ORCID: 0009-0008-6114-1698

Received: 27 February 2026
Accepted: 25 March 2026

Revised: 19 March 2026
Published online: 30 March 2026



ABSTRACT

This article presents the authors' views on the topic of defense construction as a subject of scientific research, its content and scope, as well as some current problems of defense construction in today's Mongolia.

Keywords: defense construction, subjects of research in defense construction, military-industrial complex

Батлан хамгаалах байгуулалтын судалгаа, тулгамдсан асуудал

Баттогтох Балжинням¹, Шижээ Паламдорж²

¹Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хурандаа, докторант
b.baljinnyam24@gmail.com, ORCID: 0009-0004-4243-7064

²Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн Цэргийн урлаг судлалын төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор,
Palamdorjsh1948@gmail.com, ORCID: 0009-0008-6114-1698

ХУРААНГУЙ

Батлан хамгаалах байгуулалт нь шинжлэх ухааны судлагдахуун болох, түүний агуулга, хамрах хүрээний тухай, мөн өнөө үеийн Монгол Улсын батлан хамгаалах байгуулалт дахь тулгамдсан зарим асуудлыг хөндсөн зохиогчдын үзэл бодлын илэрхийлэл энэхүү өгүүлэлд тусгагдсан болно. **Түлхүүр үгс:** батлан хамгаалах байгуулалт, батлан хамгаалах байгуулалтын судлахуун, цэргийн аж үйлдвэрийн цогцолбор.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааг явуулахад харьцуулан шинжлэх, системийн хандлагад үндэслэн логик гаргалгаа, оюун дүгнэлт хийх, задлан шинжлэх аргуудыг ашиглав.

Оршил

Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2026 оныг “ХҮН ТӨВТЭЙ ХӨГЖИЛ-ШИНЭЧЛЭЛИЙН ЖИЛ” болгон зарлаж, “Эх оронч үзэлд суурилсан хүн төвтэй бодлого хэрэгжүүлэн Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлсэн бөгөөд Батлан хамгаалахын сайд Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнтэй цахимаар уулзаж, мэдээлэл хийсэн бөгөөд цаашид хэрэгжүүлэх дараах зарим арга хэмжээний тухай дурдсан. Үүнд:

- Батлан хамгаалахын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн цогц байдлыг хангана.
- Монгол Улсын Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги” анхдагч стратегийн баримт бичгийг батлуулна.
- Зэвсэгт хүчний байгуулалтыг бэхжүүлнэ.
- “Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Засгийн газрын хуралдаанаар батлуулан хэрэгжилтийг хангаж эхлэхэд онцгойлон анхаарна.
- Батлан хамгаалахын аж үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.

Иймд дээрх ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шинжлэх ухаанч байдлаар хандаж Батлан хамгаалах байгуулалтын тухай асуудлыг зайлшгүй хөндөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Нэг. Батлан хамгаалах байгуулалт шинжлэх ухааны судлагдахуун болох нь

“Цэргийн нэр томьёоны тайлбар толь”-д “цэргийн шинжлэх ухаанд “цэргийн байгуулалт-улс орныхоо батлан хамгаалах чадамжийг хангах, цэргийн хүчин чадлыг бэхжүүлэх талаарх тухайн улсын төрийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй хоорондоо харилцаа уялдаа холбоо бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, мэдээллийн болоод цэргийн арга хэмжээний цогц. Улс орноо батлан хамгаалах төрийн бодлогыг тодорхойлох, дэс дараатайгаар хэрэгжүүлэх нь Ц.б-ын үндсэн арга хэмжээ чиглэгдэнэ гэж”, “зэвсэгт хүчний байгуулалт-зэвсэгт хүчнийг байгуулах, бэхжүүлэх, бэлтгэх талаар хэрэгжүүлдэг харилцан уялдаа холбоо бүхий арга хэмжээний тогтолцоо. З.х.б нь улс орныг батлан хамгаалах цэргийн байгуулалтын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг. З.х.б-ын үндэс, зарчим нь тухайн улсын улс төрийн тогтолцоо, нийгмийн харилцаа, эдийн засгийн хөгжлөөс хамаарч байдаг зүй тогтолтой.... (Цэргийн нэр томьёоны тайлбар толь, 2014)” гэж томьёолсон.

Иймд үндэсний батлан хамгаалах байгуулалт гэсэн нэр томьёо нь шинжлэх ухааны ухагдахуун болох тухай асуудлыг манайд анх удаа профессор Ц.Дашзэвэг хөндөж “цэргийн хэрэгт “цэргийн байгуулалт” гэсэн нэр томьёог цаашид “батлан хамгаалах байгуулалт” гэж нэршиж хэвшүүлэх (Ц.Дашзэвэг, 2019)” саналаа илэрхийлж, “зэвсэгт хүчний байгуулалт” бол улс орныг батлан хамгаалах байгуулалтын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг мөн гэж “Цэргийн нэр томьёоны тайлбар толь”-д тайлбарласан тухай зарим бүтээлүүддээ тусгасан.

“Энэ саналтай судлаач бид санал нэг байгаа ч зарим өвөрмөц онцлогтой холбон үзэх аваас “цэргийн байгуулалт”, “батлан хамгаалах байгуулалт” нь ялгаатай байна хэмээн үзэж байна. Жишээ нь АНУ-ын хувьд цэргийн ажиллагаа, байгуулалт нь дэлхийг болон бүс нутгийг хамарсан байхад, ОХУ-ын хувьд цэргийн

ажиллагаа, байгуулалт нь бүс нутаг Евроази (ХАБ -СНГ)-ийг хамарсан байна. Эндээс эдгээр улсын цэргийн ажиллагаа, байгуулалт нь өөрийнхөө улс, эх орноо “батлан хамгаалах байгуулалт”-аас өргөн хүрээтэй, “цэргийн байгуулалт” дотор “батлан хамгаалах байгуулалт” (Ш.Паламдорж, 2024) багтаж байна.

Нөгөө талаас манай улс лугаа жижиг улс орныг авч үзэхэд, тэдгээр улс нь зөвхөн өөрийгөө хамгаалах зорилготой байна. Энэ үүднээс асуудлыг авч үзвэл Монгол Улс Үндсэн хуульдаа “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” гэж заасан тул “батлан хамгаалах байгуулалт” дотор нь “цэргийн байгуулалт” нь багтаж байна.

Тэгэхээр цэргийн хэрэгт “цэргийн байгуулалт” гэсэн нэр томъёог цаашид “батлан хамгаалах байгуулалт” гэж нэршиж хэвшүүлэх нь шинжлэх ухаан талаасаа учир дутагдалтай байна. Судлаач бид социализмын үеийн болон цаг хугацааны хувьд хуучирч буй цэргийн шинжлэх ухааны нэр томъёо, ухагдахуунд болгоомжтой хандаж байх үндэслэл байна. Энэ нь тэр үед цэргийн шинжлэх ухаанд ач холбогдол илүүтэй өгч, батлан хамгаалах шинжлэх ухааныг орхигдуулж ирсэн бидний практиктай холбоотой байна. Тэр үеийн “цэргийн байгуулалт”-ын тухай тодорхойлолт “батлан хамгаалах байгуулалт”-тай дүйж байсан байж болох юм.

Өнөө үед “цэргийн байгуулалт”-ын асуудал нь “зэвсэгт хүчний байгуулалт”-ыг өөртөө багтаасан “төрийн цэргийн байгуулал”-тай холбоотой өргөн хүрээний ухагдахуун юм.

“Цэргийн байгуулалт” нь түүнээс өргөн хүрээний асуудал “батлан хамгаалах байгуулалт”-ын агуулгад багтаж байна.

Мөн манай зарим судлаачид “Батлан хамгаалах шинжлэх ухаан гэж байна” гээд батлан хамгаалах шинжлэх ухааны шинж, үүрэг, судалгааны чиглэл, үндсэн категори (ухагдахуун), нэр томъёо, зарчмын тодорхойлолт, хууль, зүй тогтлыг тайлбарлаад түүнд цэргийн шинжлэх ухаан багтана гэж өөрийн улсын онцлогтой уялдуулан тайлбарласан байдаг (Ш.Паламдорж, 2024).

Энэ бүхнийг эргэцүүлэн шинжлээд бид “үндэсний батлан хамгаалах байгуулалт нь гаднын аюул заналхийллээс иргэд, улс, эх орноо хамгаалахын тулд улсын цэргийн байгууллага, дэд бүтцийг хөгжүүлэх цогц, тасралтгүй үйл явц бөгөөд үүнд батлан хамгаалах бодлого, стратеги, цэргийн номлолыг боловсруулах, орчин үеийн төрийн цэрэг (зэвсэгт хүчин) -ийг байгуулах, байлдааны бэлэн байдлыг хангах, зэвсэг, цэргийн техник хэрэгслээр хангах, хөгжүүлэх, боловсон хүчнийг сургаж бэлтгэх, эдийн засаг, хүн амыг өөрийгөө гаднын халдлага, түрэмгийллээс хамгаалахад сургах, дайчлах, бэлэн байдлыг хангах зэргийг багтаасан цогц арга хэмжээний нэгдэл” байна гэсэн тодорхойлолтыг санал болгож байна. Энд зөвхөн цэргийн төдийгүй цэргийн бус аюулгүй байдлыг хангах аргуудыг багтаана.

Үндэсний батлан хамгаалах байгуулалтын практик нь өнөөгийн олон улсын цэрэг-улс төрийн нөхцөл байдал; улсын газарзүйн байршил; эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшин; хүн амын тоо, бүтэц; бэлтгэгдсэн цэргийн алба хаагчдын хүртээмж; улсын нутаг дэвсгэрийн цэргийн дэд бүтэц, үйл ажиллагааны хөгжлийн байдал; цэргийн шинжлэх ухаан, цэргийн урлагийн хөгжил зэрэгтэй нийцсэн байх учиртай арга хэмжээний цогц юм.

Энэ цогц бүтэц бүхий батлан хамгаалах байгуулалтын асуудлыг практикаар шийдвэрлэж ирсэн уламжлал байдаг ч өнөө үеийн нийгмийн тогтвортой хөгжил нь түүнд шинжлэх ухаанчаар хандахыг шаардаж байна.

Хоёр. Батлан хамгаалах байгуулалтын үндсэн судлахуун

“Зэвсэгт хүчний байгуулалт” гэсэн нэр томъёог Зэвсэгт хүчний тухай хуульд тодорхойлж З.х.б-ын үндэс, зарчмыг хуульчилсан байх бөгөөд “Батлан хамгаалах байгуулалт”, “Цэргийн байгуулалт” гэсэн нэр томъёо Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг, Батлан хамгаалах багц хууль болон бусад хуульд энэ нэрээр тодорхойлогдож тусгагдаагүй байна.

Профессор Ц.Дашзэвэг Батлан хамгаалах байгуулалтын үндсэн арга хэмжээг олон улсын нийтлэг жишигт харьцуулан авч үзээд “Монгол Улс батлан хамгаалах байгуулалтын үндсэн асуудлыг хууль тогтоомждоо “улс орныг батлан хамгаалах үндсэн арга хэмжээ” хэмээн томъёолон тусгаж, үе шаттай хэрэгжүүлж байна. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт улс орноо батлан хамгаалах бодлогын улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, эрх зүйн хийгээд цэргийн чиглэлийг тодорхойлж өгсөн нь улсын батлан хамгаалах байгуулалтын зорилтыг тодорхойлж буй хэрэг юм” гэж “Батлан хамгаалах тогтолцоо бэхжүүлэх зарим асуудалд” сэдэвт бүтээлдээ онцолсон байна.

Үндэсний батлан хамгаалах байгуулалтын үндсэн асуудалд: үндэсний батлан хамгаалах бодлого, стратеги, цэргийн номлолыг боловсруулах; батлан хамгаалах байгуулалтын зохион байгуулалт болон батлан хамгаалах төрийн удирдлагын тогтолцоог тодорхойлох; төрийн цэргийн байгууллын тогтолцоог тогтоох; үндэсний батлан хамгаалах төрийн удирдлагыг бүрдүүлж төлөвшүүлэх; батлан хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх; үндэсний батлан хамгаалах ложистик (зэвсэг, цэргийн техник, тоног төхөөрөмж, дэд бүтэц), боловсон хүчний бодлого (сургалт, нийгмийн хамгаалал), батлан хамгаалах дэд бүтцийн хөгжил болон олон улсын хамтын ажиллагаа, түүнчлэн улсын бүрэн эрхт байдал, ашиг сонирхлыг хамгаалах улсын дайчилгааны бэлэн байдал зэрэг асуудал багтана хэмээн үзэж байна. Үүнийг арай дэлгэрүүлж авч үзвэл, *үндэсний батлан хамгаалах байгуулалтын үндсэн асуудалд:*

- Үндэсний батлан хамгаалах бодлого, стратеги, цэргийн номлол: Үүгээр дэлхийн болон бүс нутгийн цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн нөхцөл байдал болон аюул заналхийллийн эрсдэл, цэрэг-стратегийн байдалд үнэлгээнд үндэслэн батлан хамгаалахын зорилго, зорилт, зарчмуудыг тодорхойлно.
- Батлан хамгаалах байгуулалтын зохион байгуулалт: Үүнийг үндэсний батлан хамгаалах бодлогыг тодорхойлогч төрийн улс төрийн удирдлага тодорхойлох бөгөөд үндсэн хуульд тусгалаа олсон байна. Батлан хамгаалах болон төрийн цэргийн байгууллын тогтолцоо, харьцааг болон нэгэн удирдлагыг хуульчилна.
- Батлан хамгаалах төрийн удирдлагын тогтолцоо: Үүнийг Үндсэн хууль, Аюулгүй байдлын тухай, Батлан хамгаалах тухай, Онц байдлын тухай, Дайны байдлын тухай хуулиудад дайн, энхийн цагаар ялгаж тогтооно. Цэргийн удирдлагын зарчмыг тогтоож хуульчилна.
- Батлан хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт: Үүнийг УИХ тогтоон батлах

ба хяналт тавих бөгөөд дэлхийн улс орнуудын жишгээр хэрэгжүүлнэ. УИХ төсвийн мөчлөгийн үндсэн дөрвөн үе шаг бүрд батлан хамгаалах зардалд анхаарал хандуулах учиртай: Төсвийн төлөвлөлтийн үе шатанд: гүйцэтгэх засаг тодорхой зорилгуудын дагуу төсөв хуваарилах санал дэвшүүлэх бөгөөд парламент УИХ-ын гишүүд албан болон албан бус механизмаар дамжуулан өөрсдийн саналаа нэмэрлэх боломжтой. Төсөв батлах үе шатанд: УИХ төсвийн хуваарилалтыг судлан үзэж, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж буй эсэхийг болон зохист байдлыг тодорхойлох бөгөөд зарим нөхцөлд аюулгүй байдалтай холбоотой хуваарилалтад зориулсан нарийвчилсан зааварчилгаа гаргаж болно.

- Төсвийн зарцуулалтын шатанд: УИХ Засгийн газрын зарцуулалтыг хянан үзэх бөгөөд ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхийг эрмэлзэнэ. Нэмэлт зарцуулалтын хүрээнд төсвийн тодотгол хийх шаардлага гарсан тохиолдолд УИХ төсвийн зарлагыг хэтрүүлэхгүйн тулд эдгээр шаардлагыг сайтар судлан үздэг. Аудит, үнэлгээний үе шатанд: УИХ, Засгийн газрын хуваарилсан төсвийг зүй бусаар зарцуулсан эсэхийг хянан үзнэ. Үүнээс гадна, хариуцлагатай, үр дүнтэй, оновчтой байдлыг баталгаажуулах зорилгоор УИХ нийт төсөвт болон аудитын явцад тогтмол үнэлгээ хийнэ.
- Батлан хамгаалах ложистик, эдийн засаг, дэд бүтэц: Батлан хамгаалахын ложистик, улсын эдийн засаг, дэд бүтэц нь хоорондоо нягт холбоотой бөгөөд ложистик нь зэвсэгт хүчний хангалтын (галт хэрэглэлээс эхлээд хүнс хангамжийн бүх зүйл хүртэл) хөдөлгөөн, дэмжлэгийг хангадаг, эдийн засаг нь энэ системийг дэмжихээс гадна системийн доторх үр ашиг, зардлыг бууруулах, нөөцийн удирдлагад анхаарлаа төвлөрүүлдэг бөгөөд дэд бүтэц (эрчим хүч, холбоо, тээвэр, боомтууд, агуулахууд, тээврийн сүлжээ) нь бүх ложистикийн ажлуудыг биелүүлэхийг баталгаажуулдаг бодит үндэс бөгөөд батлан хамгаалах байгуулалтыг стратегийн хувьд ашигтай, эдийн засгийн хувьд үндэслэлтэй болгодог. Батлан хамгаалах ложистикийн үндсэн асуудалд хангамж (буудлагын зэвсгийн сум, түлш, эмнэлгийн хэрэгсэл), засвар үйлчилгээ, тээвэрлэлт (газар, далай, агаар), агуулах, эмнэлгийн дэмжлэг, хээрийн байгууламж барих зэрэг багтдаг. Батлан хамгаалах ложистикийн үндсэн зорилго нь цэрэг (зэвсэгт хүчин)-ийн дайчилгааны болон байлдааны бэлэн байдлыг хангах, байлдах чадварыг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангахад оршдог. Энэ нь улсын төр засгийн удирдлага болон эдийн засаг, хөгжлийн болон сангийн яам, дэд бүтэц (холбоо, цахилгаан, эрчим хүч,)-ийн яамдын бодлого, үйл ажиллагааны дэмжлэг, хамтын ажиллагааны үр дүнгээр биеллээ олно.
- Үндэсний батлан хамгаалах болон цэргийн боловсон хүчин: Мэргэшсэн (олон янзын шаталсан сургалт, мэргэшүүлэлтээр) чухал боловсон хүчингүйгээр төрт улс орших боломж хязгаарлагдмал тул онцгой анхаарал (нийгмийн хамгаалал, хувь хүмүүсийн ашиг сонирхолтой алба, ажлыг уялдуулж, цэргийн алба хаагчдыг элсүүлэх, сургах, нийгмийн хамгаалал, мэргэжлийн арми байгуулах, орон сууц, тэтгэврийн эрхийг хангах зэрэг)-д байлгадаг.
- Шинжлэх ухаан, технологийн бүрэн эрхт байдал: Энэ нь улсын хөгжил, нөөцтэй холбоотой байдаг бөгөөд шинжлэх ухаан, технологийн ололтыг

батлан хамгаалах ашиг сонирхолд нэвтрүүлэхэд батлан хамгаалах-аж үйлдвэрийн цогцолбор (БАҮЦ) чухал үүрэг гүйцэтгэдэг.

- Байлдааны болон дайчилгааны бэлэн байдал: Цэргүүдийг даалгавар гүйцэтгэхэд байнгын бэлэн байдалд байлгах, цэргийн хүчийг бий болгох чадварыг хангах.
- Мэдээлэл ба кибер аюулгүй байдал: Мэдээллийн системийг хамгаалах, кибер аюул заналхийллийг эсэргүүцэх.
- Олон улсын цэргийн хамтын ажиллагаа: Цэргийн салбарт бусад улс орнуудтай харилцах, түүний дотор цэрэг-техникийн хамтын ажиллагаа зэрэг багтана.

Үндэсний батлан хамгаалах байгуулалтын дээрх үндсэн асуудлаас харахад, энэ нь их өргөн хүрээний ухагдахуун байх бөгөөд далайцтай, шинжлэх ухаанч байдлаар хандахаас өөр арга замгүй нь ойлгогдож байна.

Батлан хамгаалах байгуулалт яагаад шинжлэх ухааны асуудал болж буйг дараах үндэслэл, гаргалгаагаар дэлгэрүүлэн илэрхийлж болно хэмээн үзэж байна: **Нэгд**, батлан хамгаалах байгуулалт, төрөл бүрийн салбарын мэдлэгийг нэгтгэхийг шаарддаг учраас салбар дунд (хооронд)-ын хамааралтай байна. **Хоёрт**, батлан хамгаалах байгуулалт, улс төрийн тогтолцоо (систем), нийгмийн үйл явц, үзэл суртал, ёс суртахуун судлалтай холбогдож байдаг нь улс төрийн шинжлэх ухаан ба социологийн шинжлэх ухаантай нэгдмэл чанартай, түүний онцлог шинжийг өөртөө агуулж байна. **Гуравт**, батлан хамгаалах байгуулалт, улс орны эдийн засаг, санхүүгийн чадавхтай шууд хамааралтай, түүнээс гаргалгаатай байхын зэрэгцээ, улсын эдийн засаг, санхүүжилт, технологийн бүрэн эрхт байдал, тогтвортой хөгжлийг хангадаг агуулгаараа эдийн засаг, санхүүгийн аюулгүй байдал, сорилт, эрсдэлээс хамгаалдаг шинжтэй судлагдахуун байна. **Дөрөвт**, батлан хамгаалах байгуулалт, цэргийн болон зэвсэгт хүчний байгуулалт, цэргийн хүчээр батлан хамгаалах байгуулалтын зорилтыг хэрэгжүүлэх цэргийн урлаг (стратег, операц, тактикт) зэрэг цэргийн шинжлэх ухааны үндсэн асуудлыг өөртөө агуулж байдаг нь цэргийн шинжлэх ухааныг өөртөө багтаасан үндэсний батлан хамгаалах шинжлэх ухааны судлагдахуун болж байна. **Тавд**, батлан хамгаалах байгуулалт, үндэсний батлан хамгаалах философийн асуудал болохын зэрэгцээ улс, нийгмийн сэтгэл зүйгээс хамаарахын хувьд философи, социологийн болон нийгмийн сэтгэл судлалын ухаантай хамааралтай байна. Хувь хүн, нийгмийн урам зориг, ухаарал, хүсэл эрмэлзэл, нийгмийн үнэт зүйлсийг ойлгох нь үндэсний батлан хамгаалах байгуулалтыг төгөлдөржүүлэхэд эерэг нөлөөтэй байна. **Зургаад**, батлан хамгаалах байгуулалт нь системчилсэн хандлагыг шаарддаг. Үндэсний батлан хамгаалах байгуулалт нь хамтран ажиллах ёстой хүний нөөц, материаллаг нөөц, дэд бүтэц, удирдлагыг багтаасан систем юм. Энэ байдал нь системийн шинжилгээ хэмээх шинжлэх ухаанч хандлагатай холбоотой байна. **Долоод**, батлан хамгаалах байгуулалт нь улс, нийгэмд тохиолдож болзошгүй аюул заналхийллийг урьдчилан таамаглах, урт хугацааны төлөвлөлт, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицохыг шаарддаг бөгөөд энэ нь удирдлагын шинжлэх ухааны загварчлал, шинжилгээний салбар болдог. **Наймд**, үндэсний аюулгүй байдлын нийтлэг зорилгод хүрэхийн тулд янз бүрийн чиглэлээр асуудлыг нэгэн зэрэг цогц шийдвэрт тулгуурладагтай үндэсний батлан хамгаалах байгуулалт нягт холбогддог учраас

аюулгүй байдлын шинжлэх ухаантай уялдаа холбоотой байна.

Иймээс үндэсний батлан хамгаалах байгуулалт нь улс төрийн шинжлэх ухаан, социологи, эдийн засаг, цэргийн шинжлэх ухаан, сэтгэл судлал, философи зэрэг олон салбарын мэдлэгийг хамарсан, нарийн төвөгтэй, олон салбарыг дамнасан шинжлэх ухааны асуудал юм. Энэ нь зөвхөн цэргийн хүчийг ашиглах төдийгүй улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг хамгаалах, хангах улс төр, дипломат, нийгэм, эдийн засаг, мэдээлэл, технологи, хүн ам, орчныг хамардаг. Энэ бол зөвхөн цэргийн асуудал биш, харин холбогдох нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд салбар дундын арга барил шаарддаг системийн судалгааны ажил юм.

Энэ бүхнийг нэгтгэн харваас, үндэсний батлан хамгаалах байгуулалт нь цэргийн арга хэмжээний цогц биш, харин үндэсний ашиг сонирхлыг хамгаалах олон шинжлэх ухааны салбар дээр суурилсан хэрэглээний шинжлэх ухаан болж байна.

Гурав. Батлан хамгаалах байгуулалтын тулгамдсан зарим асуудал

Үндэсний батлан хамгаалах байгуулалтыг бүрдүүлэх, хөгжүүлэхэд, онцгойлон анхаарах шинжлэх ухааны зарим нэг асуудлыг илэрхийлье гэж бодож байна.

Батлан хамгаалах тухай хуульд “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагатай байна” гэж заасан. Өнөөдрийн байдлаар Батлан хамгаалах яамны харьяанд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд батлан хамгаалах байгуулалтад **Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн цогцолбор** (батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл) болон иргэний аж үйлдвэрүүд, шинжлэх ухаан, технологи, инновацын салбарыг оролцуулах явдал юм.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн цогцолбор (БХАҮЦ) нь эдийн засгийн маш чухал салбар бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын батлан хамгаалах чадварыг бүрдүүлэхийн тулд зэвсэг, цэргийн болон тусгай техник хэрэгслийн үйлдвэр, батлан хамгаалахын судалгааны хүрээлэнгүүд, зохион бүтээх товчоо, ложистик зэргээс бүрддэг. Түүний үүрэг бол технологийн бие даасан байдал, инновацын хөгжлийг (иргэний салбарт ч багтана) хангах, цэргийн хэрэгцээнд зориулсан өндөр технологийн бүтээгдэхүүнээр батлан хамгаалах байгуулалтыг өөрийн эрх хэмжээний хүрээнд хангах явдал юм.

БХАҮЦ-ын гол салбаруудыг ОХУ-ын жишгээс харахад, уламжлал ёсоор цэрэг-аж үйлдвэрийн цогцолбор (ЦАҮЦ)-т багтдаг үйлдвэрлэлийн салбарууд байна. Үүнд; нисэхийн салбар; уламжлалт зэвсгийн салбар; сум хэрэгсэл, тусгай химийн бодисын үйлдвэрлэл; электроникийн үйлдвэрлэл (радио, харилцаа холбоо, электроникийн үйлдвэрлэл); хөлөг онгоцны үйлдвэрлэл; пуужин, сансрын үйлдвэрлэл гэх зэрэг.

БХАҮЦ-ын үндэсний батлан хамгаалах байгуулалт төдийгүй үндэсний аюулгүй байдлыг хангахад нэн ач холбогдолтой болохыг дараах хэдэн үзүүлэлтээр илэрхийлж болох юм. Үүнд:

Нэгд, Төр, иргэдийгээ цэрэг дайны аюулаас, тухайлбал бөмбөгийн дэлбэрэлт,

сумнаас хамгаалах хэрэгслийг хөгжүүлэх, үйлдвэрлэх, үй олноор устгах зэвсгийн хөнөөл, хордуулалт, халдваржуулагчаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эм, тариа, боолт хэрэгслийн иж бүрдлийг бэлтгэх гэх мэт нь хувь хүн, нийгэм, улсынхаа аюулгүй байдлыг хангахад чиглэдэг байдлаар нь;

Хоёрт, БХАҮЦ нь инновацыг бий болгож, дэвшилтэт салбарууд (нисэх онгоц, сансрын хөлөг, дрон, мэдээллийн технологи)-ыг хөгжүүлж, улмаар иргэний салбарт нөлөөлдөг манлайллаар нь;

Гуравт, Ажил эрхлэлт, эдийн засгийн өсөлт, технологийн бие даасан байдлыг хангаж, импортоос хамаарлыг бууруулах замаар улс орныхоо эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад үзүүлдэг дэмжлэгээр нь;

Дөрөвт, Гадаад улс орнуудаас хамааралтай батлан хамгаалах зориулалттай стратегийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, нөөцийг бүрдүүлэх болон дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хувь нэмэр оруулдаг байдлаар нь;

Тавд, БХАҮЦ зорилго, зорилтуудаараа шууд болон шууд бусаар улсын үйлдвэрлэл, нийгэм болон дэд бүтцийн хөгжилд түлхэц үзүүлдэг. Энэ нь батлан хамгаалах аж үйлдвэр, ложистикийн хөгжил дэвшлээр нь;

Зургаад, Дан болон хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүнийг хөгжүүлж, цэрэг, армийн байлдааны ажиллагааны бүтээмжийг тасралтгүй шинэчилж, сайжруулахад дэмжлэг үзүүлдэг зэргээр нь;

БХАҮЦ өөрийн шууд харьяаны судалгааны хүрээлэн, зохион бүтээх товчоо, үйлдвэрлэлийн байгууламжууд (үйлдвэрүүдийн нэгдэл), мөн зэвсэг, цэргийн болон тусгай техник болон бусад зүйлийг туршдаг төв, туршилтын полигон, баазтай байдаг.

Шинжлэх ухааны судалгаа, санхүүжилтгүйгээр бид үндэсний батлан хамгаалах байгуулалтыг бүрдүүлэх, хөгжүүлэх ямар ч боломжгүй юм. Батлан хамгаалах байгуулалтад технологийн шинэчлэлийн сорилтуудыг даван туулахад, өөрийн санхүү, эдийн засгийн тэнцвэргүй чадавхтай байдлаа хүлээн зөвшөөрч, шийдлүүдийг олох шаардлагатай учир бид шинжлэх ухаан, технологийг “дагах” хөгжлөөр биш “угтах” хөгжлөөр түүнийг хангах учиртай хэмээн үзэж байна.

Бидний үзэж байгаагаар, цэрэг-техникийн хамтын ажиллагаа нь манай батлан хамгаалах байгуулалтын хөгжлийн гол хөдөлгөгч хүч хэвээр байна. Үүний зэрэгцээ зэвсэг, цэргийн техник экспортлохоор хязгаарлагдахгүй байх нь чухал юм. Бид хамтарсан хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлж, өөрийн бүтээгдэхүүнээ лицензтэй үйлдвэрлэх шаардлагатай байна. Манай өөрийн техник хэрэгслийн чанар муу, өрсөлдөх чадваргүй байдал нь цэрэг-техникийн хамтын ажиллагааны гэрээнд нөлөөлж болох талтай байна.

Цэргийн зохион бүтээгчдийн бүтэцтэй, лабораторитой, туршилт, үйлдвэрлэлийн цогцолбортой болох шаардлагатай байна. Энэ бол батлан хамгаалах салбарын хөгжлийн стратегийг мэдэгдэхүйц өөрчилж чадах оюуны чадавх юм.

Үндэсний батлан хамгаалах байгуулалт нь цэргийн байгууллага байгуулах, түүний тасралтгүй хөгжил, улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахын тулд төрөөс авч хэрэгжүүлж буй эдийн засаг, нийгэм-улс төр, үзэл суртлын, цэргийн болон бусад харилцан уялдаатай арга хэмжээний цогц болно.

Батлан хамгаалах байгуулалт нь улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах үндсэн баталгаа юм. Энэ нь зөвхөн зэвсэгт хүчинд хамаарах ойлголт биш бөгөөд хууль эрх зүй, эдийн засаг, иргэдийн оролцоо, олон улсын хамтын ажиллагааг хамарсан цогц үйл ажиллагаа билээ. Ялангуяа Монгол Улсын хувьд энхийг эрхэмлэсэн бодлоготой уялдан хэрэгждэг батлан хамгаалах байгуулалт нь улс орны тогтвортой хөгжил, ирээдүйн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Дүгнэлт

Улс орныг батлан хамгаалах нь улс үндэстний язгуур ашиг сонирхлын асуудал учир батлан хамгаалах байгуулалт нь улсыг удирдах төрийн бодлого, стратегийн асуудал болохын хувьд шинжлэх ухааны нэгэн чухал судлагдахуун болж байна. Түүний агуулга, хамрах хүрээг тогтоож байгаа нь шинжлэх ухааны байгууллага, судлаачдын үүрэг, шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмрийн илэрхийлэл хэмээн үзэж байна. Тэр тусмаа “Батлан хамгаалах аж үйлдвэрийн цогцолбор” нь өнөө үеийн улс орны батлан хамгаалах байгуулалтын тулгамдсан асуудлын нэг мөн болж байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Саранборжигон Ц.Дашзэвэг. Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх зарим асуудалд. УБ., 2024 он. -180н; ISBN 978-9919-0-3761-1; т.6;
2. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014 он.”Соёмбо дринтинг” ХХК. ISBN 978-99973-70-21-1; т.347-348;
3. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. Долоо. Төрийн цэргийн байгуулал.
4. Шижээгийн Паламдорж. Батлан хамгаалах судлал. УБ, 2024он. -127н; ISBN 978-9919-0-2953-1; т.64-оос хойш;